



## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ



- Төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа өмнөх жилүүдийнхээс эрс сайжирч, идэвх оролцоо нэмэгдсэн.
- Томоохон эмнэлэг, эрүүл мэндийн төвд авлигаас урьдчилан сэргийлэх тусгайлан арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлэв.

## СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



- Бага насны хүүхдүүдэд зориулсан зөв, шударга амьдралын дадал хэвшүүлэх "Туулайхүүгийн адал явдал" номыг эрхлэн хэвлүүлэв.
- Хүүхэд багачууд, оюутан залууст зориулсан шударга ёсны аян, тусгайлан хотолборт сургалтуудыг зохион байгуулав.

## СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ



- Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх тосооллийн судалгааны дүнг олон нийтэд мэдээлэв.
- Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлийн судалгааг зохион байгуулав.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ



- Хяналт шалгалтын хүрээг өргөжүүлж, илэрсэн зөрчил, дутагдалд хүлээлгэх хариуцлагын чанарыг нэмэгдүүлж ажиллав.
- Иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдол, мэдээллийн тоо эрс нэмэгдсэн бөгөөд хүлээн авсан болон хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тоо мөн нэмэгдсэн дүнтэй байна.

## МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТ



- Улсын хэмжээнд **38423** мэдүүлэг гаргагчийн **38422** нь хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлсэн бөгөөд энэ нь **99.9** хувийн амжилттай байв.
- Мэдүүлгийн хяналт шалгалтад хамрагдах албан тушаалтнуудын тоог өмнөх онуудынхаас нэмэгдүүлж, хүлээлгэх хариуцлагыг чангатгаж ажиллав.

## МӨРДӨН ШАЛГАХ



- Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хээл хахууль авах гэмт хэрэг хамгийн өндөр хувийг эзэлж байв.
- Эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан **410** хүний **28**-д нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь өмнөх оньхоос буурсан үзүүлэлт байна.

## ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ



- Гэмт хэргийн шинэжтэй гомдол, мэдээллийг хянан үзэж, эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өнгөрсөн оньхоос өссөн дүнтэй байна.
- Иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлын дийлэнх нь ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан болон хууль бус томилгоотой холбоотой асуудал байв.

## ТӨСӨВ САНХҮҮ



- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хянуулах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах зэрэг төсөв санхүүтэй холбогдох багц ажлыг хангалттай сайн гүйцэтгэв.

## НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ



- Авлигатай тэмцэх газрын авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сар бүрээр, мөн тоон хэлбэрээр бэлтгэж, иргэд олон нийтэд тогтмол хүргэх ажлыг зохиосон.
- Бүрэн эрх, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд шууд хүргэх замаар иргэдтэй нүүр тулсан уулзалтыг зохион байгуулав.

## ГАДААД ХАРИЛЦАА



- Ази, Номхон далайн орнуудын Авлигын эсрэг санаачилгын удирдах зөвлөлийн уулзалт, бус нутгийн семинарыг монголдоо анх удаа амжилттай зохион байгуулав.
- Авлигын тосооллийн индексийн 2015 оны дүнгээр Монгол Улс **168** орноос **39** оноогоор **72** дугаар байрт жагссан бөгөөд энэ нь өмнөх оньхоос **8** байр ахсан үзүүлэлт юм.